

“РЕМИКОН”ХК-ИЙН  
“ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ”-ИЙН  
ХУРЛЫН ШИЙДВЭР

---

2022 оны 03-р сарын 18-ны өдөр

Дугаар 22/2/8

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай*

“Ремикон” ХК-ийн 2022 оны 03-р сарын 18-ны өдрийн “Төлөөлөн Удирдах Зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Ремикон” ХК-ийн ээлжит “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ыг **2022 оны 04 дүгээр сарын 29-ны** өдрийн **Баасан гаригт 11.00 цагт** “Ремикон”ХК-ийн үйлдвэрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2022 оны 04 дүгээр сарын 11-ны** өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд санал авах хуудас болон хурлын материалтай “Гаүли” ХХК брокер дилерийн компани дээр **2022 оны 03-р сарын 28-ны** өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцсугай.
4. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг **2022 оны 04 дүгээр сарын 25-ны** 17:00 цаг хүртэл брокер дилерийн компанид буюу “Гаүли” ХХК-ийн байран дээр авахаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай “Хувьцаа Эзэмшигч”-дэд зарлах өдрийг **2022 оны 03 дугаар сарын 23-ны** өдрөөр тогтоосугай.
6. “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ыг зохион байгуулах комиссын даргаар Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаярыг томилсугай.
7. “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ын даргаар Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Эрдэнэбаярыг томилсугай.
8. “Хувьцаа Эзэмшигчдийн Хурал”-ын тооллогын комиссын даргаар Ч.Мөнгөнсүхийг, гишүүнээр Т.Одмаа нарыг томилсугай.

9. “Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал”-аар хэлэлцэх асуудлын жагсаалтыг *Хавсралт №1*–ээр баталсугай.
10. “Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал”-ын талаарх хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд мэдээллэх зарын загварыг *Хавсралт №2*–оор баталсугай.
11. “Ремикон” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурал-д санал авах хуудсыг *Хавсралт №3*-аар баталсугай.
12. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг *Хавсралт №4*-өөр баталсугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд



.....(Д.Алтанхуяг)

.....(Р.Ганхуяг)

.....(С.Баянмөнх)

.....(Ч.Мөнгөнсүх)

.....(Э.Мөнхсайхан)

.....(Б.Батсайхан)

.....(Ц.Эрдэнэбаяр)

.....(Х.Хашчимэг)

.....(Х.Гантулга)

2022.03.18-ны өдрийн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ... дугаар тогтоолын нэгдүгээр хэсэрт

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДАХАД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ



### Хэлэлцэх асуудал:

1. Ремикон ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,
2. Ремикон ХК-ийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах,
3. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,
4. Ремикон ХК-ийн дүрмийг шинэчлэн найруулж батлах,
5. Ремикон ХК-иас 2021 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,
6. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

2022.03.18-ны өдрийн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн... дугаар тогтоолын хоёрдугаар хэсэрт

## РЕМИКОН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН АНХААРАЛД



“Ремикон” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн Баасан гаригт 11.00 цагт** Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Ремикон ХК-ийн үйлдвэрийн байранд зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Ремикон ХК-ийн 2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах,
2. Ремикон ХК-ийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөтэй танилцах,
3. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох,
4. Ремикон ХК-ийн дүрмийг шинэчлэн найруулж батлах,
5. Ремикон ХК-иас 2021 оны санхүүгийн жилийн ашигаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар танилцуулах,
6. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагаа санхүүгийнхаа тайланг танилцуулах,

Ремикон ХК-д хувьцаа эзэмшигч ээлжит хурлын материалтай Гаули ХХК брокер дилерийн компанийн байранд 2022 оны 03-р сарын 28-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцана уу.

РЕМИКОН ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Утас:88881996, 88065253, E-mail; [info@remicon.mn](mailto:info@remicon.mn)

2022.03.18-ны өдрийн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн... дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

РЕМИКОН ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН БЭЛТГЭЛ ЯВЦАД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ  
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ



1. Ремикон ХК-ийн 2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
2. Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д заасны дагуу Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох шийдвэр,
3. Шинэчлэн найруулсан дүрэм
4. Ремикон ХК-иас 2021 оны санхүүгийн жилийн ашгаас Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хувиарлахгүй талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол,
5. Монгол улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааны тайлан

2022.03.18-ны өдрийн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн... дугаар тогтоодын гуравдугаар хавсралт



РЕМИКОН ХК-ийн 2022 оны ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....  
Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар .....  
Регистрийн дугаар .....  
Санал өгөх хувьцааны тоо .....

**Хэлэлцэх асуудлууд**

№	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэрс	Дэмжих саналын тоо
Z	Хараат гишүүд	
1.	Х.Гантулга	
2.	Б.Багсайхан	
3.	Х.Хашчимэг	
4.	Ч.Мөнгөнсүх	
5.	Ц.Эрдэнэбаяр	
6.	Э.Мөнхсайхан	
	Хараат бус гишүүд	
7.	Д.Алтанхуяг	
8.	Р.Ганхуяг	
9.	С.Баянмөнх	

Санамж: ТУЗ-ын гишүүдийг кумулятив аргаар сонгоно.

Энэ аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсвэл хэд хэдэн хүнд хувааж өгөх эрхтэй.

Нэр дэвшигч бүрд өгсөн саналын эрхийн тооны нийлбэр нь тухайн хувьцаа эзэмшигчийн саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцаа эзэмшдэг гэвэл таны санал өгөх эрхийн тоо ТУЗ-д 1х100=100 ширхэг байна. Таны нэр дэвшигч бүрт өгсөн саналын тоо нийлбэр нь таны санал өгөх эрхийн нийт тооноос илүү байж болохгүй. Хэрвээ илүү гарсан тохиолдолд тань саналын хуудас хүчингүй болно гэдгийг анхаарна уу.

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан
2	2021 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн Ремикон ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах		
3	Ремикон ХК-ийн дүрмийг шинэчлэн найруулж батлах		

**Жич:** Хэрэв та хуралд биечлэн оролцох боломжгүй бол өөрийн итгэмжлэлт төлөөлөгчийг оролцуулах буюу 2022 оны 04 сарын 25-ны дотор бөглөсөн саналын хуудсаа харьяа брокер дилерийн компанид хүргүүлж саналаа өгч болно.

Брокер...../ /

Хувь нийлүүлэгч...../ /

**Тооллогын комиссын бөглөх хэсэг:**

1. Саналын хуудсыг хүчинтэйд тооцов.
2. Саналын хуудсыг хуудсыг хүчингүйд тооцов.

Шалтгаан.....

Тооллогын комиссын дарга.....